



**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 17 өдөр

Дугаар A-258

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкийг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, БАНКИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмын зорилго нь Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу банкнаас дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкийг шинэчлэх төлөвлөгөөг боловсруулах, түүнийг агуулга, загвар, төлөвлөгөөнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох, төлөвлөгөөг Монголбанкинд ирүүлэх, Монголбанк уг хүсэлт, төлөвлөгөөг хянахтай холбогдох харилцааг зохицуулна.

ХОЁР. БАНКНААС ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

- 2.1. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 7.1-д заасны дагуу дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг Монголбанкинд хүргүүлэх шийдвэрийг гаргаж, банкийг шинэчлэх төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэж баталсны үндсэн дээр уг хүсэлтийг тухайн банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан бичгээр хэлэлцэж баталсан Банкнийг шинэчлэх төлөвлөгөөний хамт Монголбанкинд ирүүлнэ.
- 2.2. Энэ журмын 2.1-д заасан хүсэлтэд банкнаас Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн дагуу өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах хүрээнд авсан арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тус шаардлагыг хангаж чадаагүй эсхүл Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 5.3-д заасан хугацаанд хангах боломжгүй гэж үзсэн үндэслэлийн талаарх мэдээллийг тусгаж, эдгээрт холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

ГУРАВ. БАНКИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 3.1. Энэ журмын 2.2-д заасан Банкнийг шинэчлэх төлөвлөгөөнд банк өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг олон хувилбараар тооцоолж, хувилбар тус бүрт банкны төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад чиглэсэн хариу арга хэмжээг тусгах бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан мэдээллийг агуулсан байна:

- 3.1.1. Өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах зорилгоор нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээний санал;
 - 3.1.2. Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх шаардлагыг хангаж, төрөөс оруулсан хөрөнгийг Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 13.2-т заасан хугацааны дотор төсөвт буцаан төвлөрүүлэх төлөвлөгөө;
 - 3.1.3. Банкны үйл ажиллагааг хэвийн, тогтвортой, ашигтай түвшинд хүргэх 3 жилийн төлөвлөгөө;
 - 3.1.4. Орлого, зарлага болон санхүүгийн тайлангийн 3 жилийн төсөөлөл;
 - 3.1.5. Санхүүгийн бүтцийг сайжруулах, актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө;
 - 3.1.6. Үндсэн үйл ажиллагаанаас бусад хөрөнгө оруулалтыг бууруулах төлөвлөгөө;
 - 3.1.7. Банкны үйл ажиллагааны зардлын хяналтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө;
 - 3.1.8. Санхүүжилтийн зардлыг хянах, орлогын бүтцийг сайжруулах төлөвлөгөө;
 - 3.1.9. Чанаргүй зээлийг бууруулах, удирдах талаар Монголбанкны журамд нийцсэн стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө;
 - 3.1.10. Банкны засаглал, үйл ажиллагаа, дотоод бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах төлөвлөгөө;
 - 3.1.11. Зээлийн үйл ажиллагааны стандартыг сайжруулах төлөвлөгөө;
 - 3.1.12. Банкны холбогдох болон харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээлийг 3 жилийн хугацаанд бууруулах төлөвлөгөө;
 - 3.1.13. Монголбанкнаас тухайн банкинд өгсөн үүрэг даалгавар, арга хэмжээний төлөвлөгөөг тогтоосон хугацаанд бүрэн хангахыг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл;
 - 3.1.14. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 3.2. Банк Банкийг шинэчлэх төлөвлөгөөг боловсруулахад ашигласан мэдээллийн эх сурвалж, судалгаа, тайлбарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкинд ирүүлнэ.
 - 3.3. Монголбанк шаардлагатай гэж үзвэл банкийг шинэчлэх төлөвлөгөөг сайжруулах, шинэчлэх арга хэмжээ авах, нэмэлт баримт бичиг, мэдээлэл ирүүлэхийг тухайн банкнаас шаардана.
 - 3.4. Банкийг шинэчлэх төлөвлөгөөг энэхүү журмын хавсралтаар батлагдсан загварт үндэслэн боловсруулж, холбогдох мэдээллийг нэмж тусган, баримт бичгийг хавсаргана.

ДӨРӨВ. ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ, БАНКИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАН ҮЗЭХ, ЗӨВШӨӨРӨХ

- 4.1. Монголбанк банкнаас ирүүлсэн дахин хөрөнгөжүүлэх хүсэлт, Банкнийг шинэчлэх төлөвлөгөөг хүлээн авснаас хойш Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 7.5-д заасан хугацаанд хянан үзнэ.
- 4.2. Банкнийг шинэчлэх төлөвлөгөөг шинэчлэх, сайжруулах, нэмэлт баримт бичиг, тайлбар, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Монголбанк энэ талаар дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргасан банкинд мэдэгдэнэ.
- 4.3. Банкнийг шинэчлэх төлөвлөгөө, төлөвлөгөөтэй холбоотой нэмэлт шаардлагатай баримт бичиг, тайлбар, мэдээллийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт, Банкнийг шинэчлэх төлөвлөгөөг хүлээн авсан өдөрт тооцно.
- 4.4. Монголбанк Банкнийг шинэчлэх төлөвлөгөө бодитой хэрэгжих боломжтой, төлөвлөгөөтэй холбоотой тайлбар, судалгаа нь үндэслэлтэй гэж үзвэл Банкнийг шинэчлэх төлөвлөгөөг энэ журмын 4.1-д заасан хугацаанд зөвшөөрнө.

ТАВ. БУСАД

- 5.1. Банк Банкнийг шинэчлэх төлөвлөгөөг энэ журмын 2.1-д заасан хугацаанд ирүүлээгүй, эсвэл төлөвлөгөөг Монголбанк бодитой хэрэгжих боломжгүй, төлөвлөгөө, дахин хөрөнгөжүүлэх хүсэлттэй холбоотой тайлбар, судалгаа нь үндэслэлгүй гэж үзэж төлөвлөгөөг зөвшөөрөөгүй нь банкнийг дахин хөрөнгөжүүлэх саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээс татгалзах үндэслэл болно.
- 5.2. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 7.1 болон энэ журамд заасны дагуу дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргасан банкинд тус хуулийн 8.2-т заасны дагуу Банкны тухай хуульд заасан холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдолд банкнийг шинэчлэх төлөвлөгөөг шинэчлэн ирүүлэх арга хэмжээг холбогдох этгээд авна.

МОНГОЛБАНК

“Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах,
банкийг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах
журам”-ын хавсралт /загвар/

БАНКИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

... оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

Банкны оноосон нэр:

Банкны хаяг:

Хэлэлцэж баталсан эрх бүхий этгээд:

Шийдвэрийн огноо, дугаар:

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа:

Хэрэгжүүлэх этгээд:

Нэмэлт мэдээлэл:

Шаардлагатай гэж үзсэн бусад:

Хавсаргасан баримт бичиг:

Гарын үсэг

Огноо